



---

## ТООН ГАРЫН ҮСГИЙН ГЭРЧИЛГЭЭ ОНЛАЙНААР ШИНЭЧЛЭН АВАХ ЗААВАР

---

Хэрэглэгчдэд зориулсан гарын авлага

Боловсруулсан:

“МонПасс СА” ХХК ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ БАЙГУУЛЛАГА

Хаяг: Монгол улс, Улаанбаатар хот, БЗД, 13 хороолол, 18-р хороо

Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж, 14/4 байр 4 давхар

Утас: +976 18002535 | Факс: +976 76113286

И-Мэйл: [info@monpass.mn](mailto:info@monpass.mn) | Веб сайт: [www.monpass.mn](http://www.monpass.mn)

Хувилбар	Огноо
1.0	2020 он

## АГУУЛГА


1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	3
2. СИСТЕМД НЭВТРЭХ .....	3
3. ТГҮГ СУНГАХ ЗАХИАЛГА ҮҮСГЭХ.....	4
4. СУНГАХ ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ.....	8
5. ТӨЛБӨР ТӨЛӨХ .....	10
6. БҮРТГЭЛИЙН НЭГЖИЙН АЖИЛТАН ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ.....	12
7. ТОКЕН ТӨХӨӨРӨМЖ ДЭЭР ТГҮГ – НИЙ ХҮСЭЛТ ҮҮСГЭХ, ГЭРЧИЛГЭЭ СУУЛГАХ .....	13

## 1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Аж ахуйн нэгж, байгууллагын өмнө нь тоон гарын үсгийн гэрчилгээ(ТГҮГ), токен төхөөрөмж авсан албан тушаалтны ТГҮГ – ий хүчинтэй хугацаа дууссан эсвэл хүчинтэй хугацаа дуусах дөхсөн тохиолдолд ТГҮГ – ээ онлайнгаар шинэчлэн авах боломжтой. Та дараах зааврын дагуу ТГҮГ – ээ шинэчлэн авна уу.


## 2. СИСТЕМД НЭВТРЭХ

[www.monpass.mn](http://www.monpass.mn) вэб сайт-д байгууллагынхаа эрхээр буюу нэвтрэх нэр, нууц үг ашиглан нэвтрэнэ.



Зураг 1. Захиалгын системд нэвтрэх цонх

- Нууц үгээ мартсан бол [Нэвтрэх](#) цонхон дээр байгаа [Нууц үг сэргээх](#) линк дээр дарж бүртгэлтэй и-мэйл хаягаараа нууц үгээ шинээр авах боломжтой
- Нэвтрэх нэрээ мартсан бол 18002535 дугаар, эсвэл [info@monpass.mn](mailto:info@monpass.mn) мэйл хаягаар хандан мэдэх боломжтой.



Зураг 2. Нууц үг сэргээх цонх

### 3. ТГҮГ СУНГАХ ЗАХИАЛГА ҮҮСГЭХ

Системд нэвтэрч орсны дараа дэлгэцийн зүүн гар талын цэсээс **ТГҮГ СУНГАХ** цэс дээр дарсанаар танай байгууллагын албан тушаалтнуудын авсан ТГҮГ-үүдээс хүчинтэй хугацаа нь дууссан болон хугацаа нь дуусах дөхсөн ТГҮГ –үүдийн жагсаалт харагдана. Жагсаалт дээр сунгах хүсэлт гаргаагүй байгаа ТГҮГ **Сунгах хүсэлт илгээх** гэсэн төлөвтэй байна.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ		ТГҮГ сунгах жагсаалт						
КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ	+	<input checked="" type="checkbox"/> Сунгах хүсэлтийн Нэхэмжлэх үүсгэх						
МИНИЙ ЗАХИАЛГУУД	+	<input type="checkbox"/>	<b>Регистр</b>	<b>Овог, нэр</b>	<b>Хэлтэс/Албан тушаал</b>	<b>Төлөв</b>	<b>Дуусах огноо</b>	<b>Н:</b>
ОЛГОГДСОН ТООН ГАРЫН ҮСГҮҮД	+	<input type="checkbox"/>	ЙР82091360	Т.Тест	Тест / Тест	Имэйлээр ирсэн линк баталгаажуулах	2021-02-23 22:56:13	
ТГҮГ СУНГАХ	-	<input type="checkbox"/>	ТЕ45654654	Т.ТестГоломт	ТестГоломт / ТестГоломт	Баталгаажсан	2020-12-22 03:27:39	
НЭХЭМЖЛЭХҮҮД	+	<input type="checkbox"/>	OE91051710	Т.Тест	Test / Test	Имэйлээр ирсэн линк баталгаажуулах	2021-01-28 04:11:49	
ХҮЧИНГҮЙ ГЭРЧИЛГЭЭ	+	<input type="checkbox"/>	OE91051710	Г.Баасансүрэн	Тест / Тест	Төлбөр төлөх	2020-10-30 21:26:41	164 Хугацаа дууссан
ТУСЛАМЖ	+	<input type="checkbox"/>	OE91051710	Г.Баасансүрэн	Тест / Тест	Имэйлээр ирсэн линк баталгаажуулах	2020-10-30 20:34:56	Хугацаа дууссан
		<input type="checkbox"/>	OE91051710	Г.Баасансүрэн	Тест / Тест	Имэйлээр ирсэн линк баталгаажуулах	2020-10-30 20:34:56	Хугацаа дууссан
		<input type="checkbox"/>	CD11111111	Т.Тест Нэр	Тест хэлтэс / Тест албан тушаал	Гэрчилгээ суулгах	2020-09-11 23:02:12	164 Хугацаа дууссан
		<input type="checkbox"/>	ЭЭ52522222	Т.Тест2	Тест2Хэлтэс / Тест2Албантушаал	Сунгах хүсэлт илгээх	2020-07-31 03:25:35	Хугацаа дууссан
		<input type="checkbox"/>	ТТ88888888	Т.Тест1	ТестХэлтэс / ТестАлбантушаал	Сунгах хүсэлт илгээх	2020-07-31 03:25:32	Хугацаа дууссан
		<input type="checkbox"/>	OE91051710	Т.Тест	Test OU / Test title	Сунгах хүсэлт илгээх	2020-07-04 12:08:27	Хугацаа дууссан

Зураг 3. Шинэчлэн авах боломжтой ТГҮГ –үүдийн жагсаалт



- Эдгээрээс сунгахыг хүссэн ТГҮГ – г сонгож дээр нь дарж дэлгэрэнгүй мэдээллийг харах бөгөөд мэдээллийг нягталж баталгаажуулаад **Гэрчилгээ сунгах** товч дээр дарна.

**Олгогдсон тоон гарын үсгийн гэрчилгээ** ✕

**ГЭРЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

\* Гэрчилгээний дугаар: 56D07699000000009924 \* Олгосон огноо: 2019-07-05 12:08:27

\* Дуусах огноо: 2020-07-04 12:08:27

**БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

\* Байгууллагын нэр: Тест ХХК \* Байгууллагын РД: 1234567

**ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ**

\* Эцэг/Эхийн нэр: Test \* Регистрийн дугаар: OE91051710

\* Өөрийн нэр: Test \* Албан тушаал: Test title

\* И-мэйл хаяг: baasansuren@monpass.mn \* Утас:

**ТООН ГАРЫН ҮСГИЙН МЭДЭЭЛЭЛ**

1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/	1 жил	20,000.00
2	Тоон гарын үсгийн тээгч төхөөрөмж	Тийм	40,000.00

**Гэрчилгээ сунгах** Хаах

Зураг 4 Сунгах гэж буй ТГҮГ – ий дэлгэрэнгүй мэдээлэл

- ТГҮГ сунгах хугацааг сонгож **Үргэлжлүүлэх** товчийг дарна. /Токен төхөөрөмжөө хаясан тохиолдолд **Токен төхөөрөмж шинээр авах эсэх** гэдэг сонголт дээр **Тийм** гэдгийг сонгоно. Бусад тохиолдолд хэрэглэгч өөрийн токен дээр ТГҮГ сунгаж авах тул **Үгүй** сонгоно. /

Сунгах боломжтой гэрчилгээний төрөл

1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/	<input checked="" type="radio"/> 1 жил <input type="radio"/> 2 жил
2	Токен төхөөрөмж шинээр авах эсэх	<input type="radio"/> Тийм <input checked="" type="radio"/> Үгүй
Бараа ажил үйлчилгээний үнэ:		20000
НӨАТ:		2000
Нийт дүн:		22000

Зураг 5 ТГҮГ-ий төрөл сонгох цонх

- Байгууллагын албан тушаалтны ТГҮГ сунгахыг удирдлагын зүгээс баталгаажуулах албан бичиг ирүүлэх шаардлагатай бөгөөд Үргэлжлүүлэх товч дарснаар албан бичгийн драфт харагдана.
- Албан бичигтэй танилцаж мэдээллүүдээ нягталж шалгаад **хадгалах** товчийг дарна.

ТГҮГ гэрчилгээ сунгах баримт ×

["МОНПАСС СА" ХХК ГОБ-д]

["Тоон Гарын Үсгийн Гэрчилгээ шинэчлэн авах хүсэлт"]

Манай байгууллагын ажилтан Test овогтой Test нь 2020 оны 12 сарын 04 нд Test title-ын албан тушаал дээр Тоон гарын үсгийн гэрчилгээ авсан ба гэрчилгээний хугацаа дуусаж байгаа тул Тоон Гарын Үсгийн Гэрчилгээ 1 жилийн хугацаатай шинэчлэн авах хүсэлтэй байна. Доор дурдсан мэдээлэл өөрчлөгдөөгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

**Байгууллагын мэдээлэл**

Улсын бүртгэлийн дугаар	Байгууллагын Регистрийн дугаар	НД төлөгчийн дугаар	Байгууллагын нэр	Хаяг
1111111111	1234567	000234567	Тест ХХК	Токиогийн гудамж, 12 байр, 3 тоот

**Ажилтаны мэдээлэл**

Овог	Нэр	Регистрийн дугаар	Албан тушаал	Утас
Test	Test	OE91051710	Test title	

Тест : ...../T.Test11/

Албан бичиг татах
Хадгалах
Хаах

Зураг 6 ТГҮГ сунгах албан хүсэлт

- Сунгах хүсэлт амжилттай үүссэнээр **Мэйлээр ирсэн линк баталгаажуулах** гэсэн төлөвтэй болно.

#### 4. СУНГАХ ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

ТГҮГ сунгах хүсэлтийг 2 янзаар баталгаажуулна.



1. ТГҮГ эзэмшигч өөрөө энэ хүсэлтийг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг өмнө нь авсан гэрчилгээн дээр бичигдсэн эзэмшигчийн мэйл хаягруу мэйл илгээж баталгаажуулна.

Таньд энэ өдрийн мэндийг хүргэе!

Таны тоон гарын үсгийн гэрчилгээг сунгах хүсэлт “Монпасс СА” ТГҮГ олгох байгууллагад ирсэн байна. Та дараах мэдээллийг шалгаж хүсэлтийг баталгаажуулах линк дээр дарж баталгаажуулна уу!

Байгууллагын нэр: Тест ХХК  
Албан тушаал: Test title  
Эцэг/эхийн нэр: Test  
Өөрийн нэр: Test  
Регистрийн дугаар: OE91051710  
Холбоо барих утас:  
Баталгаажуулах линк **Энд дар**

Танд амжилт хүсье.  
Хүндэтгэсэн,

 Утас: +976-18002535  
И-Мэйл: [info@monpass.mn](mailto:info@monpass.mn)  
Вэб: [www.monpass.mn](http://www.monpass.mn)  
Skype: monpassca.mn  
Хаяг:  Монгол улс, Улаанбаатар хот, БЗД, 13 хороолол 18 хороо Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 14/4 байр 4 давхар

### Анхаар:

**!** ТГҮГ эзэмшигчийн мэйл хаягаар хүсэлт баталгаажуулах холбоос бүхий имэйл очих бөгөөд эзэмшигч холбоос дээр дарж баталгаажуулна.

**Зураг 7** Гэрчилгээ эзэмшигчийг баталгаажуулах мэйл


Мэйл шалгаж баталгаажуулснаар хүсэлт маань **Албан бичиг хавсаргах** төлөвт шинжинэ.

<input type="checkbox"/>	OE91051710	T.Test	Test OU / Test title	<b>Албан бичиг хавсаргах</b>	2020-07-04 12:08:27 <b>Хугацаа дууссан</b>
--------------------------	------------	--------	----------------------	------------------------------	---



**Зураг 8** ТГҮГ сунгах хүсэлтийн жагсаалт

- Тухайн албан тушаалтанд ТГҮГ олгохыг хүлээн зөвшөөрч байгаа эсэхийг удирдлагын зүгээс баталгаажуулна. Ингэхдээ сунгах хүсэлт үүсгэх үед албан бичиг татагдана. Татаж авсан албан бичгийг захирлын тоон гарын үсгээр баталгаажуулах эсвэл байгууллагын албан бланк дээр хэвлэж байгууллагыг төлөөлөх эрх бүхий гүйцэтгэх удирдлага тамга дарж гарын үсэг зурж баталгаажуулна.

ТГҮ зурж баталгаажуулсан эсвэл гараар зурж, тамга дарсан албан бичгийг сканнердан PDF форматаар хавсаргана.



Зураг 9 PDF форматаар албан бичиг хавсаргах



Зураг 10 PDF форматаар албан бичиг хавсаргах

#### Анхаар:

! Албан бичгийг Хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгэлтэй байгууллагыг төлөөлөх эрх бүхий гүйцэтгэх удирдлагын гарын үсгээр баталгаажуулна.

! Уламжлалт аргаар гарын үсэг зурж тамга дарж сканердаж илгээж байгаа тохиолдолд тамга тод гарсан байна. Шаардлагатай тохиолдолд эх хувийг шуудангаар илгээнэ.

## 5. ТӨЛБӨР ТӨЛӨХ

- Төлбөр төлөхийн өмнө **Сунгах хүсэлтийн нэхэмжлэх үүсгэх** товчийг дарж нэхэмжлэх үүсгэнэ.
- Нэхэмжлэх үүссэний дараа танилцаад хадгалах товч дарна.

**Анхаар:**

**!** Та онлайн төлбөрийн систем ашиглан, эсвэл банкинд очиж төлбөр шилжүүлэх бол Гүйлгээний утга талбарт зөвхөн татаж авсан Нэхэмжлэхийн дугаар болох 12 оронтой тоог бичнэ үү.

Хувийн мэдээлэл	ТГҮГ сунгах жагсаалт					
КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ	<a href="#">Сунгах хүсэлтийн Нэхэмжлэх үүсгэх</a>					
МИНИЙ ЗАХИАЛГУУД	<input type="checkbox"/>	Регистр	Овог, нэр	Хэлтэс/Албан тушаал	Төлөв	Дуусах огноо
ОЛГОГДСОН ТООН ГАРЫН ҮСГҮҮД	<input type="checkbox"/>	ЙР82091360	Т.Тест	Тест / Тест	Имэйлээр ирсэн линк баталгаажуулах	2021-02-23 22:56:13
ТГҮГ СУНГАХ	<input type="checkbox"/>	TE45654654	Т.ТестГоломт	ТестГоломт / ТестГоломт	Баталгаажсан	2020-12-22 03:27:39
НЭХЭМЖЛЭХҮҮД	<input type="checkbox"/>	OE91051710	T.Test	Test / Test	Имэйлээр ирсэн линк баталгаажуулах	2021-01-28 04:11:49
ХҮЧИНГҮЙ ГЭРЧИЛГЭЭ	<input type="checkbox"/>	OE91051710	Г.Бавсансүрэн	Тест / Тест	Төлбөр төлөх	2020-10-30 21:26:41
ТУСЛАМЖ	<input type="checkbox"/>					161

Зураг 11 Нэхэмжлэх үүсгэх

Нэхэмжлэх			
"МонПасс СА" ХХК Д/р: 6010709 Дансны дугаар: Голomt банк: 2205110546		Утас: 976-18002535 info@monpass.mn http://www.monpass.mn	Монгол улс, Улаанбаатар хот, БЗД, 13 хороолол 18 хороо Манлайбаатар Денжинсүрэнгийн гудамж, 14/4 байр 4 дөвхр
НЭХЭМЖЛЭХ		ТӨЛӨГЧ Тест ХХК 1234567 8988888 Монгол улс, Улаанбаатар, Баянгол дүүрэг, Токмогийн гудамж, 12 байр, 3 тоот	
Мөнгөн дүн төгрөгөөр			
№	Гүйлгээний утга	Тоо ширхэг	Нэгжийн үнэ
1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/ 1 жил	1	20,000.00
Баруу ажил үйлчилгээний үнэ:			20,000
НВАТ:			2,000
Нийт дүн:			22,000.00
<p><b>Нэмэлт мэдээлэл:</b> Та тоон гарын үсгийн гэрчилгээ авахдаа дараах баримт бичгийг бүрдүүлэх шаардлагатай. Гэрээ, албан бичиг, нэхэмжлэх болон итгэмжлэхийн загварыг онлайнар хүсэлтээ бөглөсний дараа гарч ирэх холбоосоор татаж авна.</p> <p><b>Банкинд төлбөр төлөхдөө:</b> Төлбөр төлөх дансны дугаар: Голomt банк 2205110546. Хүлээн авагч: МОН ПАСС СА ХХК. Банкны баримтын гүйлгээний утга талбарт зөвхөн Нэхэмжлэхийн дугаар болох 12 оронтой тоог бичнэ. Өөр ямар нэг мэдээлэл бичихгүйг анхаарна уу.</p> <p><b>Бүртгэлийн байгууллагад очихдоо бүрдүүлэх ёстой баримт бичгүүд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>Гэрээ 2% (хүсэлтээ бөглөсний дараа татан авч, хэвлэж гарын үсэг зурж, захирлаар батлуула);</li> <li>Иргэний үнэмлэх, түүний хуулбар;</li> <li>Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар батлуулсан хуулбар;</li> <li>Байгууллагын албан бичиг (хүсэлтээ бөглөсний дараа татан авч, захирал гарын үсэг зурж, тамга дарсан байна);</li> <li>Итгэмжлэх (зэмшигч өөрийн биеэр гэрчилгээг хүлээн авах боломжгүй үед өөрийгөө төлөөлөн гэрчилгээ авах хүнд олгоно. Итгэмжлэхийн маягтыг <a href="https://monpass.mn/support">https://monpass.mn/support</a> хаягаас татаж авч, нотариатаар баталгаажуулсан байна);</li> </ul>			
			<a href="#">Хадгалах</a> <a href="#">Хаах</a>

Зураг 12 Нэхэмжлэх

- Нэхэмжлэх амжилттай үүсч хадгалагдсан тохиолдолд хүсэлт **Төлбөр төлөх** төлөвтэй болно.
- Төлбөр төлөхдөө **НЭХЭМЖЛЭХҮҮД** цэсрүү орж картаар төлөх боломжтой. Эсвэл нэхэмжлэхийн дугаар болох 12 оронтой тоог гүйлгээний утга дээр бичин нэхэмжлэх дээрх голомт банкны 2205110546 дансруу шилжүүлэн төлбөрөө төлөх боломжтой.

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ		Нэхэмжлэхүүд					
КОМПАНИ МЭДЭЭЛЭЛ	+	Нэхэмжлэх үүсгэх					
МИНИЙ ЗАХИАЛГУУД	+	Нэхэмжлэх №	Огноо	Нэхэмжилсэн	Төлөв	Үйлдэл	Устгах
ОЛГОГДСОН ТООН ГАРЫН ҮСГҮҮД	+	160707642775	2020/12/04	44,000	Шинэ	Картаар төлөх	Татах
ТГҮГ СУНГАХ	+	160698407337	2020/12/03	22,000	Төлөгдсөн	Татах	
<b>НЭХЭМЖЛЭХҮҮД</b>	<b>-</b>	160698066936	2020/12/03	66,000	Шинэ	Картаар төлөх	Татах
ХҮЧИНГҮЙ ГЭРЧИЛГЭЭ	+	159981585856	2020/09/11	66,000	Төлөгдсөн	Татах	
ТУСЛАМЖ	+	159358365783	2020/07/01	66,000	Төлөгдсөн	Татах	

Зураг 12 Нэхэмжлэхүүд


- Төлбөр амжилттай төлөгдсөн тохиолдолд нэхэмжлэх **Төлөгдсөн** төлөвт орно.
- Хэрэв **Төлөгдсөн** төлөвтэй болохгүй бол төлбөрийн баримтаа [info@monpass.mn](mailto:info@monpass.mn) имэйлээр хавсаргаж илгээнэ үү.

## 6. БҮРТГЭЛИЙН НЭГЖИЙН АЖИЛТАН ХҮСЭЛТИЙГ БАТАЛГААЖУУЛАХ

Төлбөр төлсний дараа Монпасс ГОБ-ийн бүртгэлийн нэгж (БН)-ийн ажилтан хүсэлтийг цахимаар хүлээн авч ажлын 3 өдөрийн дотор шалгаж баталгаажуулна. Шаардлагатай тохиолдолд гэрчилгээ эзэмшигч болон байгууллагын удирдлага руу утсаар болон бусад харилцаа холбооны хэрэгслээр холбогдож мэдээлэл өгнө. Яаралтай тохиолдолд ажлын цагаар манай лавлах 18002535 утсаар болон бусад хэрэгслээр холбогдож мэдэгдэх боломжтой.

## 7. ТОКЕН ТӨХӨӨРӨМЖ ДЭЭР ТГҮГ – НИЙ ХҮСЭЛТ ҮҮСГЭХ, ГЭРЧИЛГЭЭ СУУЛГАХ

Бүртгэлийн нэгжээс хүсэлтийг шалгаж баталгаажуулсан бол гэрчилгээ эзэмшигчийн мэйлд дараах агуулга бүхий мэйл очно.



*Зураг 12 ТГҮГ сунгах хүсэлтийг баталгаажуулах мэйл*

- Гэрчилгээ эзэмшигч **Баталгаажуулах линк** дээр дарж нэвтрэх нэр, Нэг удаагийн нүүц үгийг оруулна.
- Нэвтрэх нэр, нэг удаагийн нүүц үг амжилттай баталгаажсан тохиолдолд ТГҮГ суулгах цонх гарч ирэх бөгөөд захиалгын мэдээллийг шалгаж баталгаажуулаад суулгах товчийг дарж токений пин кодыг оруулсанаар таны токен төхөөрөмж дээр шинэ давтагдашгүй хос түлхүүр үүсч ТГҮГ үүсгэх хүсэлт Монпасс ГОБ – ын серверт илгээгдэнэ.

**Анхаар:**

**!** Та суулгах үйлдэл хийхээсээ өмнө токен төхөөрөмжөө компьютерт залгаж, Монпасс клиент програмаа ажиллуулсан байх шаардлагатайг анхаарна уу.

Тоон Гарын Үсгийн Гэрчилгээ суулгахын тулд та нэвтрэнэ үү

baasansuren@monpass.mn

.....

**Нэвтрэх**

Зураг 13 Нэвтрэх

Тоон Гарын Үсгийн Гэрчилгээ суулгах

**БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЭЛ**

\* Байгууллагын нэр: Тест ХХК \* Байгууллагын РД: 1111111111

\* Харьяа нэгж (хэлтэс, алба): Test OU

**ЭЗЭМШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ**

\* Эцэг/Эхийн нэр: Test \* Регистрийн дугаар: OE91051710

\* Өөрийн нэр: Test \* Албан тушаал: Test title

\* И-мэйл хаяг: baasansuren@monpass.mn \* Утас:

**ТООН ГАРЫН ҮСГИЙН МЭДЭЭЛЭЛ**

1	Ажилтаны тоон гарын үсгийн гэрчилгээ /Class-3/	1 жил
2	Тоон гарын үсгийн тээгч төхөөрөмж	Үгүй

**Суулгах** Хаах

Зураг 14 ТГҮГ үүсгэх цонх

Баталгаажуулалт

**MonPass Client**

Тоон гарын үсгийн сертификат удирдах, хэрэглээг хялбаршуулах зорилгоор Монпасс СА ХХК-наас Боловсруулав.

All rights reserved. Copyright 2020

**Баталгаажуулалт**

Monpass PKI eToken  
PIN Кодоо оруулна

\*\*\*\*\*

**Нэвтрэх** Бүцах

Зураг 15 Токен төхөөрөмжийн нууц оруулах

**Амжилттай**


Таны тоон гарын үсгийн хос түлхүүр амжилттай үүслээ

Зураг 16 анхааруулах мессеж

- Токений мэдээлэл болон гэрчилгээ эзэмшигчийн мэдээлэл үнэн зөв тохиолдолд ТГҮ-ийн хос түлхүүр амжилттай үүслээ гэсэн анхааруулах мессеж гарч ирснээр таны таны ТГҮ-ийн хос түлхүүр амжилттай үүсч сунгах хүсэлт баталгаажна.
- Таны хос түлхүүр үүсч хүсэлт Монпасс ГОБ – ын системрүү илгээснээс хойш 3 цагийн дотор ТГҮГ баталгаажна. Та ТГҮГ –ээ баталгаажсаны дараа Монпасс клиент програмын **шинэ гарын үсэг суулгах** цэсээр орж ТГҮГ –ээ токен төхөөрөмж дээр суулгаснаар ашиглахад бэлэн болно.



Зураг 17 Монпасс клиент програм



Зураг 18 ТГҮГ суулгах

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА